

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
ХҮМҮҮНЛЭГИЙН САЛБАР

ISSN 2224-1804

Эрдэм шинжилгээний бичиг
№ 397 (34), 2014

ТҮҮХ

XIII

Дугаарыг эрхэлсэн О.Оюунжаргал

Улаанбаатар 2014

ISSN 2224-1804

**HISTORIA MONGOLARUM
JOURNAL OF HISTORY**

Editor in Chief:

Professor Dr.(Sc) J.Boldbaatar,
Member of Mongolian Academy of Science (Mongolia)

Deputy Editor in Chief:

Dr. P.Delgerjargal (Mongolia)

Editorial Secretary

Dr. S.Chuluun (Mongolia)

Editorial Board

Dr. Ch.P.Atwood (USA)

Dr. U.Bulag (UK)

Dr.Chimeddorj (PRC,Inner Mongolia)

Dr. Ch.Dashdavaa (Mongolia)

Dr. V.V. Graivoronskii (Russia)

Dr. H.Futaki (Japan)

Dr. (Sc) A. Ochir (Mongolia)

Dr. D.Ulziibaatar (Mongolia)

Dr. (Sc) J.Urangua (Mongolia)

This annual Journal of Mongolian History is an official journal of School of Art and Sciences, National University of Mongolia that has been published since 2001. Journal covers multilanguage studies of issues related to political, social, economical, cultural and linguistic aspects of Mongolian history of all periods. There are no any racial, religious discriminative restrictions on authors or regard-ing geographical location. On occasion of the 10th anniversary of this journal it has been re-named as "Historia Mongolarum".

Manuscripts and illustrations should be sent to the editors:

Department of History, School of Art and Sciences,
National University of Mongolia,
Ulaanbaatar- 14201, Mongolia

Tel: 976-7730-7730-2305, Fax: 976-11-328890

ГАРЧИГ

Судалгааны өгүүлэл

Мацүда Коичи. <i>Монгол улсаас олдсон Ши Гэ-гийн бэхэн бичээсийн тухай</i>	5
В. Т.Тепкеев. <i>XVII зууны сүцлээр Оросын өмнө хэсэгт Зүцнгарын өөлдүүд ирж нутагласан нь</i>	16
Г. Баярмаа. <i>Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь (1911-1915)</i>	28
Х.Мөнхбаяр. <i>Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааны тухайд</i> ..	51
Э.Лонжид. <i>Монголын төр ба мал сүрэг (1921-1959)</i>	74
Н.Алтантөгс. <i>Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл</i>	119

Судалгааны тэмдэглэл

Х.Мэндсайхан. <i>Буриадын эрдэмтэн багш Базар Санжиевич Ишдоржийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлсэн нь</i>	140
Т.Етекбай. <i>Орчин цагийн хэвлэх үйлдвэрүүд ном хэвлэлийн арга ажиллагааг өөрчилсөн нь</i>	156
Л. Чулуунбаатар. <i>“Чонын хөөлгө” ба өнөөгийн тулгамдсан асуудлууд</i>	174

Сурвалжийн танилцуулга

Ч.Улаанбарс. <i>XVII-XVIII зууны үеийн Монгол дахь худалдаачны тухай нэгэн баримтын тухай</i>	182
Б.Нацагдорж. <i>Бүцвэй бэйлийн судар хэмээх сурвалжийн тухай</i>	198
Ж.Урангуа, Л.Одзаяа. <i>“Цэрэнпилийн хэрэг”-т холбогдох баримтуудыг нэхэн эргэцүүлэхүй</i>	213

Дурсамж

Ц.Жамбалсүрэн. <i>Х.Пэрлээ багшийн тухай дурсамж</i>	250
--	-----

CONTENTS

Research article

K. Matsuda. <i>Shi Ge's Ink Inscription Found in Mongolia</i>	5
V. T. Tepkeev. <i>On the Settlement of the Ögeled's from Dzungaria to the Southern Russia at the end of 17th century</i>	16
G. Bayarmaa. <i>A Note on the Newly-Organized Yeke Šabi Office</i>	28
Kh. Munkhbayar. <i>On the Dating of the Start of the Political Repression in Mongolia</i>	51
Z. Lonjid. <i>Mongolian Government and Livestock</i>	74
N. Altantugs. <i>Poverty of Herders and Government Meat Export Policy During the First Five Year Plan</i>	119

Research note

Kh. Mendsaikhan. <i>A Political Purge Case of Buriyat Intellect Bazar Sanjievich Ishdorj</i>	140
T. Etekbai. <i>A Note on the Establishment of Modern Printing Industry</i>	156
L. Chuluunbaatar. <i>The Chase of the Wolf" and the relating Current Urgent Issues</i>	174

Introduction of Sources

Ch. Ulaanbars. <i>On a Manchu Document About a Merchant in the 17th and 18th Century Mongolia</i>	182
B. Natsagdorji. <i>Introduction of Buubei beyile-yin sudur</i>	198
J.Urangua, L.Odzaya. <i>A Reconsideration of Documents Relating to the Case "Tserenpil</i>	213

Remembrance

Ts.Jambalsuren. <i>Remembrance of Dr. Kh.Perlee</i>	250
---	-----

АНХДУГААР ТАВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛҮҮД ДЭХ МАЛЧДЫН ЯДУУРАЛ БА УЛСЫН БЭЛТГЭЛ

Н.АЛТАНТӨГС

Товч агуулга: Улсын бэлтгэл нь хямд үнээр, тарга хүч сайтай эр малыг их хэмжээгээр малчдаас худалдан авч байснаас 1948-1952 онд БНМАУ-ын ядуу ба дундаж малчдад оногдох малын тоо цөөрчээ. Зөвлөлтөөс БНМАУ-д нийлүүлдэг барааны үнэ Дэлхийн хоёрдугаар дайны үедхэддахин нэмэгдсэнээс шалтгаалж ЗХУ-БНМАУ-ын худалдаанд Монголын талдалдагдал үүсч, энэ нь малчдын нуруун дээр буужээ. Эрх баригчдын цаашдын бодлого уг алдагдлыг бууруулахад биш, харин энэ нөхцөл байдалд дасан зохицоход чиглэж, малчдын хувийн малд улсын бэлтгэлийн үүрэг оногдуулах замаар хувийн малыг хавчих болсон нь малчид нэгдэлд “сайн дураар” нэгдэн орох үндсэн шалтгаан болжээ.

Түлхүүр үг: төлөвлөгөө, давхраажилт, ядуурал, малын тоо, улсын бэлтгэл

Удиртгал

БНМАУ-ын улс, ардын аж ахуйг хөгжүүлэх Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний төгсгөлийн жил 1952 оны хавар Сэлэнгэ аймгийн Хушаат сумын малчин ард Жамц орон нутгийн захиргаанаас улсын бэлтгэлд мал тушаах жил тутмын даалгавраа хүлээн авав. 40 толгой малтай байсан малчин Жамц бэлтгэлд тэнцэхгүй мал болон өөрийн амьдрах гэр сууцаа улсын бэлтгэлд тэнцэх эр малаар сольж тэдгээр авсан малаараа улсын бэлтгэлийн үүргийг ханган биелүүлээд эцэстээ тугалтай таван үнээ, нэг шүдлэн үхэртэй, орон гэргүй үлджээ.¹ Түүн лүгээ адил Дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш 1950-иад оны төгсгөл хүртэл хугацаанд олон малчид улсын албан журмын мал, сүү, ноос бэлтгэлд хамаг шилдэг сайн малаа баран өгч байжээ.

1956 оны “Сэхээтний төөрөгдлийн” үеэр зарим сэхээтний зүгээс эрх баригчдад хандан малчдын аж амьдрал дорой байгааг сануулж, “Ард түмний аж амьдрал сайжирсаар байна гэж ухуулаад байхад байдал түүнээс өөр байна. Навч цэцгээ хотондоо мандуулаад, нар сараа гэртээ мандуулж байна” гэх буюу эсхүл “Ард түмэн хүнд байдалтай байна. Эсгий алга, сүү тос зуны цагтч алга, ард түмнээс их зүйлийг авч байна. Энэ бүх байдлыг бид мэдэж байгаа боловч ярихгүй байна”² гэх зэргээр санал, бодлоо хэлж байжээ.

¹ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 108.

² Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: Хувьсал, өөрчлөлт (XX зуун), УБ, 2008, 172-175.

Энэ бүхэн хэр үндэстэй байсан бэ? Захиргаадалтын эдийн засгийн анхны үед үнэхээр малчдын дунд ядуурал их байсан уу? Улс орноо тусгаар тогтноулж, орчин үежүүлэхээр зорьж байсан эрх баригчдын бодлого, үйл ажиллагаа яагаад хүн амын дийлэнхийг эзлэх малчдын аж амьдралд хүндрэл бэрхшээл учруулах болов? 1958-1960 онд гуравхан жилийн хугацаанд ихэнх малчид “сайн дураар” нэгдэлд элсэн орсон нь Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний үеэс эхлэн хэрэгжүүлсэн улсын бэлтгэлийн бодлоготой холбоотой юу? Улсын бэлтгэл нь малчдын хувийн мал сүргийн тоог хэрхэн өөрчилж, малчдын амьжиргаанд хэр хүчтэй нөлөөлж байсныг мэдсэнээр бид дээрх асуултуудыг хариуг олох юм.

1. Судлагдсан байдал

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн 1948-1952 оны хугацаанд мал аж ахуйд учирсан хүндрэлийн талаар албан түүхүүдэд хэрхэн тусгаж ирснийг сөхвөл, 1969 оны БНМАУ-ын түүх бүтээлд эхэнд дурьдсан малчин Жамцын адил ядуурах хандлага малчдын дунд олон болж байсныг нуухын аргагүй байсан тул энэ явдлыг малчид улсад их хэмжээний өртэй болсон хэмээн өөрөөр тайлбарлаад үүний шалтгааныг тэдэнд ногдуулах улсын албан журмын бэлтгэлийн үүргийг мал өсгөх төлөвлөгөөнд үндэслэн ногдуулах болсон ба уг зохисгүй үйл ажиллагааны шалтгаан нь нэг хүнийг тахин шүтэх үзэл мөн гэж үзжээ.³

1984 оны БНМАУ-ын түүх бүтээлд 1950-иад оны улсын бэлтгэлийн систем нь малчдын мал өсгөх санаачилгыг дээшлүүлж чадаагүй гэж илүү өнгөц дүгнээд Зөвлөлтөд гаргаж байсан мал экспорт ба малчдын ядуурлын талаар огт дурьдсангүй өнгөрчээ. Энэ тайлбарын дагуу авч үзвэл малчин Жамцын ядуурсан шалтгаан нь түүний малаа өсгөөгүйгээс болсон байна. Монголын эдийн засгийн түүхийг хөндсөн бүтээлүүдч мал аж ахуйн бүтээгдэхүүний албан журмын худалдан авалт ба экспортын анхны үеийн талаар дээрхтэй нэгэн адил хэвшмэл агуулгатай байна⁴. Монголын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэлүүдэд Монгол-Зөвлөлтийн харилцан бараа нийлүүлэх зарим гэрээг,⁵ Монгол ба Зөвлөлтийн статистикийн эмхтгэлүүдэд энэ худалдааны нийт хэмжээ ба үнийн дүнг тойм байдлаар нийтэлсэн байдаг ч эдгээр нь улсын бэлтгэлийн далайц, түүнтэй холбоотой

³ БНМАУ-ын түүх, Гутгаар боть (Нэн шинэ үе), УБ, 1969. 548-549.

⁴ Баянжаргал, Ч., *Монголын эдийн засгийн түүх*. Улаанбаатар, 2001; Бүгд Найрамдах Монгол Ард Улс социалист орнуудын эдийн засгийн түүх, Товч суралцах, УБ, 1984; БНМАУ-ын социалист эдийн засгийн түүх, УБ, 1986; Мещеряков, М.В., *Зөвлөлт Холбоот Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдийн засгийн хамтын ажиллагааны тойм*, УБ, 1959; Намжим, Т., *Монгол Улсын эдийн засаг*, Дөрвөн боть зохиол, УБ, 2004; Очирбал, Н., *БНМАУ-ын гадаад худалдаа*, УБ, 1979; Чулуун, С., *Монголын худалдаа, эдийн засгийн товчоон*, УБ, 2009.

⁵ *Монгол-Зөвлөлтийн харилцаа* (1921-1974), Баримт материал, Хоёрдугаар боть, 1941-1974, Нэгдүгээр хэсэг, Улаанбаатар-Москва, 1981, 200-203.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний
жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл

малчдын дундах ядуурлыг илрүүлэхэд хангалттай материал болж чадахгүй байна.⁶

Өрнөдөд Монголын эдийн засгийн түүхийг сонирхохдоо буурай хөгжилтэй орнуудад Зөвлөлтийн тусламж хэрхэн хүрч байгаа тухай асуудал, социалист блокын нэгэн гишүүн орны хувьд түүний төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн санхүү ба татварын системийг сонирхох сонирхол, Зөвлөлтийн зээл, тусламжийн туршлагыг судлах хүрээнд зарим судалгаа хийсэн боловч үүнд БНМАУ-ын мал аж ахуйн бүтээгдэхүүний албан журмын худалдан авалт ба экспортын талаар хөндсөн зүйл хараахан үгүй аж.⁷ Харин тухайн цаг үед Улсын төлөвлөгөөний комиссоос эрхлэн эдийн засгийн зарим судалгааг нууцын зэрэглэлтэйгээр хийхдээ малчдын дунд ядуурал нэмэгдэж байгааг анхааран авч үзэж байжээ. МУУТА дахь Улсын Төлөвлөгөөний Комиссын фондын баримт бичиг дотор хадгалагдаж буй Базарсад хэмээх ажилтны хийсэн нэгэн судалгааг үүнд дурьдаж болно.⁸ Энэ судалгаагаар малчдын давхраажилтад гарсан сөрөг өөрчлөлтийг 1945 ба 1952 онуудаар харьцуулсны үндсэн дээр дундаж ба ядуу малчид эрчимтэй ядуурч буйг олж тэмдэглээд, “Энэ дундаж ахуйнууд нь өөрийн малын аль шинээр нэмэгдэх төлийн өсөлтийг үгүй хийж өөрийн залуу малуудыгаа чинээлэг аж ахуйтанд олноор өгч оронд нь улсадалбан журмаар тушаахад нас хүйс тохирох цөөн малыг авах зэргээр мөлжигдөж дундаас ядуу аж ахуйд шилжиж байна» хэмээн ядуурлын шалтгааныг улсын албан журмын мал худалдан авах явдалтай шууд холбон тайлбарлаж, жишээ баримт дурьджээ. Уг судалгаагаар ядуурлын шалтгаанданхаарал хандуулж, ядуурлын шалтгаан нь улсын бэлтгэлийн хүрээнд эр малыг хэт ихээр худалдан авч байгаатай холбоотой гэж үзсэн боловч үүнийг шууд шалтгаан биш, харин энэ нөхцөл байдлыг далимдуулан чинээлэг малчид ядуучуудаа мөлжиж байгаа нь ядуурлын шууд шалтгаан гэж үзжээ. Тэрээр “бэлтгэлд нас хүйс тэнцэх малгүй аж ахуйтныг малтай чинээлэг аж ахуйтан нь шууд боож их хэмжээгээр мөлжиж байгааг үзүүлж байна» хэмээн дүгнээд баян нь ядуугаа мөлжих хандлагыг шүүмжилж, харин Зөвлөлтөд хэт их хэмжээний малыг хямд үнээр гаргаж байгаа, түүнийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь улсын албан журмын мал худалдан авалт болох талаар дуугүй өнгөрчээ.

Тэгвэл энэ талаар товч боловч шинэлэг дүгнэлт хийсэн бүтээл бол 2003

⁶ БНМАУ-ын улс, ардын аж ахуй 1965 онд, Статистикийн эмхтгэл, УБ, 1966; БНМАУ-ын улс, ардын аж ахуй 1981, Статистикийн эмхтгэл, УБ, 1982; БНМАУ-ын улс, ардын аж ахуй 1986, Статистикийн эмхтгэл, УБ, 1987; *Внешняя торговля СССР*, Статистический сборник, 1918-1966, Москва, 1967.

⁷ Латтимор, О. *Нүүдэлчид ба хувьсгалчид*, УБ, 1994; Rupen, R., *The Mongols of the Twentieth Century*, Indiana University Publications, 1964; Berliner, J.S., *Soviet Economic Aid: The New Aid and Trade Policy in Underdeveloped Countries*, New York, 1958; Hart, J., *Mongolia: 20th year of Economic Planning*, *Asian Survey* Vol. 8, No. 1, A Survey of Asia in 1967: Part 1 (Jan., 1968), 21-28; Holzman, F.D., *Equity of the Livestock Tax of Outer Mongolia*, *American Slavic and East European Review* Vol. 15, No. 4 (Dec., 1956), 506-510; Holzman, F. D., *The Tax System of Outer Mongolia, 1911-1955: A Brief History*, *The Journal of Asian Studies* Vol. 16, No.2, (Feb., 1957), 221-236.

⁸ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 101-113.

онд нийтлэгдсэн Монгол Улсын түүх болно. Уг бүтээлд “Капиталист бус хөгжил” буюу “социализмын үндсийг” байгуулахад шаардагдах хуримтлалын эх үүсвэрийг малчин өрхийн мал, түүхий эдийг хямд үнээр албадан авч байсан” хэмээн үзээд “Худалдаанд улсын тогтоосон хатуу үнэ, тэгшитгэн хуваарилах зарчим нь бүтээгдэхүүний өөрийн өртөг нь зах зээлийн харилцаагаар илэрхийлэгдэж байдаг таваарын үйлдвэрлэлийн мөн чанарыг алдагдуулж, ихэнхдээ малчдыг хохироож, тэдний бүтээн үйлдвэрлэсэн зүйлээр улс нийтийн аж ахуйн бусад салбарыг үүсгэн байгуулах хөрөнгийн эх үүсгэвэр болгох, улсын сангийн аж ахуй зэрэг бусад салбарын алдагдлыг нөхөхөдашиглаж байв” хэмээжээ⁹. Монголын эдийн засгийн түүхийн судалгаанд малчдыг улсын бэлтгэлийн улмаас хохироож байсан гэсэн уг дүгнэлт нь тухайн үеийн ядуурал ба баян,хоосны ялгааг авч үзэхэд чухал холбогдох боловч малчдаас албан журмаар мал худалдан авах ажиллагааны хохирлыг түүний хямд үнээр тайлбарлаж, бусад салбарыг үүсгэн байгуулах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилготой гэж үзсэнээр улсын бэлтгэлийн зорилго болсон Зөвлөлтөд мал экспортлох явдлыг бүрхэгдүүлжээ.

Энэ өгүүлээр 1950-иад оны үеийн захиргаадалтын эдийн засгийн үеийн ядуурлын тухай судлагдаагүй орон зайг хөндөж, 1948-1952 оны хооронд малчдын дунд баян, хоосны ялгаа ихэсч байсан нь Зөвлөлтөд мал экспортлох явдалтай хэрхэн холбогдохыг илрүүлж, тухайн үеийн малчдын аж байдлын шалтгааныг гадаад, дотоод орчинд нь тоймлон харахыг зорьсон болно.

2. Анхдугаар таван жилийн үеийн малчин өрх ба малын тоо

Хэдийгээр ХХ зуун нэгэнт талдаа орж, Зөвлөлтөд Дэлхийн хоёрдугаар дайны дараах сэргээн босголт, эдийн засаг, аж үйлдвэрийн хүчирхэг бүтээн байгуулалт өрнөж байсан ч Нэг ба Хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний хугацаанд БНМАУ-ын эдийн засгийг өмнөх олон мянган жилийн адилаар малчин түмэн тодорхойлсоор байв. 1950-иад оны дунд үеийг хүртэлх хугацаанд малчид БНМАУ-ын нийт хүн амын 92 хувийг эзэлж, улсын нийт мал сүргийн 98-аас дээш хувийг өмчилж байв. Хотын хүн ам маш бага байсан бөгөөд нэгдэл, сангийн аж ахуйн өмч улсын нийт мал сүргийн 2 хүрэхгүй хувийг эзэлж, улсын эдийн засагт тодорхой үүрэг гүйцэтгэдэггүй байв.

Иймээс Анхдугаар таван жилийн хугацаан дахь малчдын амьжиргааны төвшин ба түүн дэх ядуурлыг авч үзэх нь тухайн үеийн БНМАУ-ын нийт хүн амын амьжиргааны төвшинг авч үзэж буйтай ялгаагүй болно.

Хүн амын дийлэнх олонхыг бүрдүүлэгч малчин өрхүүдийн амьжиргааны төвшинг тогтоох үндсэн зүйл нь малын тоо болно. Тухайлбал, бид дээр дурьдсан малчин Жамцын ядуурсныг түүний малын тоо нэг жилийн дотор 40-өөс 6 толгой болж буурснаар хэмжиж байна. Нэг айл өрх хичнээн мал эзэмшиж байгаагаараа

⁹ БНМАУ-ын түүх, 5 дугаар боть, УБ, 2003.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний
жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл


баян, дундаж, ядуугийн аль нэгэнд хамаарч иржээ. Малчдын давхраажилтыг янз бүрээр ангилж болох боловч хамгийн ерөнхий ангилал нь 1-50 малтай ядуу өрх, 51-200 малтай дундаж өрх, 201-ээс дээш малтай чинээлэг өрх хэмээн гурван давхаргад ангилан үзэх явдал юм. Иймээс бид энэхүү ангилалд үндэслэн түүний тооны өөрчлөлтөөр ядуурал ба баян,хоосны ялгааг хэмжье.

Улсын хэмжээнд малын тоо толгой ерөнхийдөө тогтвортой байв. Анхдугаар таван жилийн хугацаан дахь малын тоог ажиглахад, хамгийн өндөр өсөлт 1949 онд 1.3 сая толгойгоор өссөн ба хамгийн олон малтай жил нь 1950 онд 22.3 сая малтай байна.

Хүснэгт 1. Малын тоо, 1946-1952 он (мянган толгойгоор)¹⁰

1946 он	1947 он	1948 он	1949 он	1950 он	1951 он	1952 он
20828.3	20724.2	20553.9	21869.8	22312.1	22306.0	22202.5

График 1



Графикаас үзэхэд Анхдугаар таван жилийн хугацааны эхэнд мал сүрэг өсөх хандлагатай байсан ч сүүлийн хоёр жилд энэ хандлага зогсч, малын тоо эргээд буурч эхэлсэн ба ерөнхийдөө тогтвортой байсан гэж үзэж болно. Энэхүү 20 орчим сая толгой мал сүргийг 1940-50-иад онд нийт 200 мянга гаруй малчин өрх малаж, нэг өрхөд дунджаар 100 мал ноогдож байв.

Гэхдээ энэ тогтвортой байдал нь малчдын давхарга тус бүрд харилцан адилгүй байлаа. Улсын төлөвлөгөөний комиссоос хийгдсэн дээр дурьдсан судалгаагаар ядуу малчдын тоо ихэсч байгаа нь тодорхой харагдаж байжээ. 1945 онд 50 хүртэлх малтай ядуу өрх 77.5 мянга байсан бол 1952 онд 79.4 мянга болж нэмэгдсэн ба 51-200 малтай дундаж өрх 114.1 мянгаас 97.9 мянга болж цөөрчээ. Харин 200-гаас дээш малтай чинээлэг өрх 19,9 мянгаас 29,5 мянга болж нэмэгджээ. Үүнийг хүснэгтээр үзүүлвэл:

¹⁰ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 95; БНМАУ-ын улс ардын аж ахуй 40 жилд, Статистикийн эмхтгэл, УБ, 1961, 44-45; БНМАУ-ын улс ардын аж ахуй 60 жилд, Статистикийн эмхтгэл, УБ, 1981, 85.


Хүснэгт 2. Малчдын давхраажилтад гарсан өөрчлөлт, мянган өрхөөр

Малчдын давхраажилт	1945 он	1952 он	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1-50 малтай	77.5	79.4	+1.9	+2.4
51-200 малтай	114.1	97.9	-16.2	-14.1
201-ээс дээш малтай	19.9	29.5	+9.6	+48.2
Нийт	211.5	206.8	-4.7	-2.2

Эх сурвалж: Улсын төлөвлөгөөний комиссоос хувийн аж ахуйтныг эзэмшин байгаа малаар нь хэсэглэж 1945 оны байдлыг 1952 оны байдалтай зэрэгцүүлсэн тодорхойлолт (Товчлон авав) МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 101.

Эндээс харахад чинээлэг малчдын давхарга эрс өргөжсөн бол дундаж малчдын давхарга 14.1 хувиар хорогдож, Жамцын хамаарагдаж буй ядуучуудын давхаргын өрхийн тоо 2.4 хувиар нэмэгджээ. Малчдын дундядуу малчдын эзлэх хувь 36.6 хувиас 38.4 хувь болж, чинээлэг малчдын эзлэх хувь 9.4 хувиас 14.3 хувь болж тус тус өссөн байхад дундаж давхаргынхан 53.9 хувиас 47.3 хувь болж цөөрчээ. Үүнийг графикаар үзүүлвэл:

График 2



Ийнхүү баян, хоосны ялгаа ихсэх хандлага малчин өрхүүдийн тооны өөрчлөлтөөс харагдаж байна. Тэгвэл энэ байдал давхарга тус бүрийн эзэмших малын тооны тухайд ямар байсныг авч үзье.

Улсын төлөвлөгөөний комиссын Худалдаа бэлтгэлийн хэлтсээс жил бүрийн мал тооллогын дүнд үндэслэн хийсэн өөр нэгэн судалгааг үзвэл 1948 онд ядуу давхаргад 77.5 мянган өрхийн 2.1 сая мал байсан бол 1952 онд 79.4 мянган өрхийн 1.1 сая мал болж ядуусын нийт мал хурдтай хорогдсон байна¹¹. Малчдын

¹¹ МУУТА, Ф-8, Д-2, ХН-553, 38.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний
жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл

дунд ядуу өрхийн тоо 2.4 хувиар нэмэгдэж, харин тэдэнд харьяалагдах мал нь 43.3 хувиар хорогджээ. Ийнхүү ядуусын мал эрс хорогдсон нь малчин Жамцын ядуурсан жишээ улсын хэмжээнд түгээмэл явдал байсныг харуулж байна. Мөн дундаж давхаргад 114.1 мянган өрхийн 11.1 сая мал хамаарч байсан бол 1952 онд 97.9 мянган өрхийн 10.4 сая мал болон буурч, дундаж давхаргынхны өрхийн тоо, малын тоо аль аль нь бага зэрэг хорогджээ. Харин энэ хугацаанд чинээлэг малчид өрхийн тоо ба малын тооны хувьд огцом олширчээ. Чинээлэг давхаргад 1948 онд 19.9 мянган өрх, 7.2 сая мал хамаарч байсан бол 1952 онд 29.5 мянган өрх, 9.8 сая мал болон нэмэгдэж, өрхийн тоо 48.2, малын тоо 35.4 хувиар өсчээ. Чинээлэг малчид зарим аймагт бүр хурдацтай олширч байсан бөгөөд тухайлбал Төв аймагт 501-1000 малтай чинээлэг давхаргынхны мал 1948 онд 66 мянга байсан бол 1952 онд 150 мянга болж өсчээ¹². Үүнийг хүснэгтээр үзүүлвэл:

Хүснэгт 3. Малчдын давхарга тус бүрийн эзэмших малын тоо, мянган толгойгоор

Малчдын давхраажилт	1948 он	1952 он	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1-50 малтай	2117.0	1198.3	-918.7	-43.3
51-200 малтай	11157.3	10461.8	-695.5	-6.2
201-ээс дээш малтай	7279.4	9861.0	+2581.6	+35.4
Нийт	20553.9	21521.1	+967.2	+4.7

Эх сурвалж: Улсын төлөвлөгөөний комиссын Худалдаа бэлтгэлийн хэлтсээс боловсруулсан Аж ахуйтны группийн хувийн жингийн хүснэгт. 1952 он. МУУТА. Ф-8, Д-2, ХН-553,38.

Нийт малчин өрхийн 38.4 хувийг эзлэх ядуу давхаргынхны малын тоо 1952 онд 1.1 сая болсон бол 14.3 хувийг эзлэх чинээлэг давхаргынхны малын тоо 9.8 сая болжээ. Өгүүлэн буй хугацаанд ядуу малчдын эзэмших малын тоо 43.3 хувиар эрс багасч, чинээлэг малчдын малын тоо 35.4 хувиар нэмэгдсэн явдал нь малчдын дунд Жамц зэрэг ядуус нь улам үгүйрч, харин чинээлэг малчид улам баяжиж байсныг харуулж байна. Үүнийг графикаар харуулвал:

Малчдын дунд ядуурал газар авч байсан талаар дээр өгүүлсэн зүйлд ядуу малчдын дундаас огт малгүй болон бүрмөсөн үгүйрээд хот, суурин газарт шилжсэн малчдын тоог авч үзэх ёстой ч энэ талаар шууд холбогдох баримт одоогоор алга. Харин Улаанбаатар хотын хүн амын тоог үзвэл 1944 онд 30.3 мянга, 1947 онд 45 мянга¹³, 1950 онд 62.5 мянга болж¹⁴ маш эрчимтэй өссөн байна.

¹² МУУТА, Ф-8, Д-2, ХН-553, 48.

¹³ МУУТА, Ф-1, Д-4, ХН-144, 30-31.

¹⁴ Улаанбаатар хот 50 жилд, УБ, 1971, 18.

Үүнийг графикаар харуулбал:
График 3





График 4



1947 онд орон нутагт 210 мянган өрх байсан бол 1951 онд 209 мянган өрх болж буурсан¹⁵ нь үүнтэй холбоотой бөгөөд 1947-1950 онд орон нутгаас Улаанбаатар хот руу ойролцоогоор 15 мянга орчим хүн шилжин суурьшиж, малчдаас төдий тооны хүн ам хасагдсан гэж үзэж болно. Эдгээр 15 мянга орчим хүний ихэнхийг огт малгүй болсны улмаас буюу эсхүл малаа зориуд зараад нийслэлийг зорьсон малчид хэмээж болох юм. Малгүй болсон өрх зарим орон нутагт ямар байсныг үзвэл, тухайлбал Хөвсгөл аймагт 1948 онд 150 өрх огт малгүй байсан бол 1952 онд энэ тоо 507 болж нэмэгдсэн байна. Сэлэнгэ аймагт 1948 онд огт малгүй 563 өрх байсан бол 1952 онд 884 болж нэмэгдсэн байна¹⁶.

Эрх баригчдаас явуулсан улсын бэлтгэлийн бодлогын улмаас малчид улсын бэлтгэлийн үүргээс зугатах, малаа зарж борлуулах явдал гарч байв. Завхан аймгийн Сонгино сумын 9 дүгээр багт Дагдан, Ням-Осор нарын зэрэг малчид 1952 онд “Одоо улсын хоёрдугаар таван жилийн төлөвлөгөө батлагдах гэж байна, тэр төлөвлөгөө гарахаас урьдбид нар айл бүр 21-ээс олонгүй малтай болох нь чухал, иймийн тулд аль болох аргаар малаа хот оруулж худалдах хэрэгтэй байна” гэдэг ятгалгыг хийж 30 гаруй малчдыг хот руу мал хөрөнгийг авахуулан нүүлгэхийг ятгаж байгаад Дотоод явдлын яамны Завхан аймаг дахь тусгай хэлтсийн хараанд өртөж байжээ¹⁷. Ийм зэргээр болон улсын бэлтгэлийн улмаас хурдацтай олширч эхэлсэн малгүй өрхүүдээс төв суурин газарт шилжин суурьших явдал энэ үеэс эхлэн нэмэгдэж эхэлсэн бололтой ба Улаанбаатар хотодуг хугацаанд нэмэгдсэн 15 мянган хүний ихэнх нь малгүй болж орон нутгаас нийслэл рүү шилжин суурьшсан малчид байж болох юм.

¹⁵ МУУТА. Ф- 1, Д- 4, ХН- 144, 30-31.

¹⁶ МУУТА. Ф- 8, Д- 2, ХН- 553, 21-25.


¹⁷ МУУТА, Ф-8, Д-2, ХН-483. 42.

3. Ноогдол ба үнэ

Малчдын ядуурсан, малгүй болсон ба чинээлэг малчидулам баяжсан дээрх байдал нь улсын албан журмын мал худалдан авалтын бодлоготой холбоотой болохыг тухайн үед Улсын төлөвлөгөөний комиссоос хийсэн судалгаанд олж тодорхойлж байсан ч үүний шалтгааныг чинээлэг малчдаас ядуу малчдад улсын бэлтгэлд тэнцэх малаа хэт өндөр үнэтэй худалдан мөлжиж байгаагаас болж байна гэж ангич байр сууринаас тайлбарласан ба үүнд мал худалдан авах үнэ, түүний хэмжээ хэрхэн нөлөөлснийг уг судалгаа болон бусад түүхийн зохиолуудад авч үзээгүй байна. Улсын албан журмын мал бэлтгэлийн системийн хүрээнд худалдан авдаг мал нь үндсэндээ үхэр ба хониноос бүрдэх ба бид хамгийн олон тоогоор нийлүүлэгдэж байсан хонины жишээгээр түүний журмыг тодруулж, энэ нь малчдын аж амьдралд хэрхэн нөлөөлснийг тодруулъя.

Дайны дараах үед Зөвлөлтөд экспортлох, дотоодод хэрэглэх зорилго бүхий улсын албан журмын хонь бэлтгэл 1940 онтой харьцуулахад 50-75 хувиар нэмэгджээ¹⁸. 1947-1952 онуудад жил бүр 1.2-1.8 сая хонь улсын хэмжээнд бэлтгэж, түүний 90 орчим хувийг Зөвлөлтөд экспортолж байв. Анхдугаар таван жилийн хугацаанд 1952 онд хамгийн их буюу 1.8 сая хонь (нийт хонины 15 хувь) бэлтгэсэн бол 1949 онд хамгийн бага буюу 1.2 сая хонь (нийт хонины 11 хувь) бэлтгэжээ¹⁹. 1947-1952 онд бэлтгэсэн хонины тоог он тус бүрээр үзүүлвэл дараах мэт.

График 5



Зөвлөлтөд тушаах хонь болон үхэр нь ихэнхдээ нас гүйцсэн эр хонь байх ёстой байв. 1950 оны байдлаар бэлтгэлийн насны эр шар үхрийн 68 хувь, эр хонины 51 хувийг албан журмаар худалдан авч, Зөвлөлтөд экспортолж байсан бол нэг жилийн дараа 1951 онд эр үхрийн 77 хувь, эр хонины 71,2 хувийг, харин

¹⁸ БНМАУ-ын улс ардын аж ахуй 40 жилд - Статистикийн эмхтгэл. УБ, 1961. 54.

¹⁹ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 99.

1952 онд эр үхрийн 80 хувь, эр хонины 79 хувийг тус тус албадан худалдан авах болжээ. Иймээс дээрх олон тооны хонь нь улсын хэмжээний эр хонины нөөцийг шавхахад хүргэж байжээ.

Эдгээр эр хонийг бүрдүүлэхдээ малчдад хуулийн хүчинтэй албан үүрэг оногдуулж байв. Албан үүрэг оногдуулах журам нь дараах байдалтай. Анхдугаар таван жилийн хугацаанд улсын албан журмын үүргийн хонь бэлтгэл нь нэг хонинд дунджаар 4.7 кг мах оногдуулах зарчмаар аймаг, сум, баг, малчин өрхүүдэд хуваарилагддаг байв²⁰. Уг дундаж ногдлоор бодож үзвэл 110 хоньтой айлд нэг хонинд 4.7 кг албан журмын ногдол оноож, энэ нь 517 кг хонь болж байна. Энэ үед нэг хонийг дунджаар 37.1 кг-аар тооцож байсан тул²¹, 517 кг хонь нь нас гүйцсэн 14 эр хонь болох юм.

110 хоньтой айлднас гүйцсэн эр хонь дунджаар нэг²², хамгийн ихээр бодоход гурваас дөрөв байх боломжтой атал журмын дагуу 110 хоньтой дундаж айлаас 14 эр хонь худалдаж авахаар шаардаж байв. Өөрт бэлэн байхгүй эр хонийг малчид хөрш зэргэлдээ чинээлэг малчин айлаас худалдан авч бүрдүүлэхээс өөр сонголт байсангүй. Гэтэл энэ үеийн улсын бэлтгэлд шаардах хонь нь нийт бэлтгэлийн насны эр хонины 51-79 хувьд хүрснээс²³ нас гүйцсэн эр хонины хомсдол үүсч түүний үнэ эрс өсч 2-3 төлөгтэй тэнцэх болжээ²⁴.

Иймээс 110 хоньтой айл хонины улсын албан журмын бэлтгэлээ хангахын тулд 10-12 эр хонийг бусдаас 20-36 тооны бага хониор чинээлэг малчдаас авч, улмаар хониных нь тоо нэг жилийн улсын бэлтгэлийг тушаасны дараа 74 хүртэл хорогдож байна. Үүний дээр нэмэхэд, улсын бэлтгэлийг бэлэн байгаа 110 малд нь биш, харин улсын төлөвлөгөө ёсоор байвал зохих малд нь оногдуулж байсан ба нийт малчдын 60-70 хувь нь мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлж чадахгүй байсан тул энэхүү хорогдол нь олон тооны малчдыг, ялангуяа бидний авч үзсэн 200 хүртэлх малтай олонх малчдыг шууд ядуурахад хүргэж байжээ.

Үүний нэгэн жишээ нь өгүүлийн эхэнд дурьдсан малчин Жамцын түүх юм. Түүний зургаан толгой малтай болж ядуурсан жишээг дотор нь задлан үзвэл, малчин Жамц улсын төлөвлөгөөгөөр 226 толгой малтай байх үүрэгтэй ч хэдэн жил дараалан малаа төлөвлөгөөнд заасан өндөр хувиар өсгөж чадаагүй тул 1952 онд ердөө 40 толгой малтай байв. Уг жинхэнэ байгаа 40 ба цаасан дээр байгаа 186, нийт 226 толгой малд улсаас 1952 онд албан журмын бэлтгэлд 1384 кг мах өгөх үүрэг ногдуулжээ. Үүнээс малчин Жамц 850 кг махыг өөрийн нөөц бололцоогоор тушаасны дараа үлдсэн 534 кг махыг тушаахын тулд улсын бэлтгэлд тэнцэх

²⁰ МУУТА, Ф-8, Д-2, ХН-553, 104.

²¹ МУУТА, Ф-8, Д-2, ХН-553, 99.

²² МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 105.

²³ МУУТА, Ф-8, Д-2, ХН-552, 12.

²⁴ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 108.

малыг бусдаас худалдан авах болсон байна. Үүнд нэг бүдүүн шар үхрийг өөрийн таван ханатай, бүрэн бүрээстэй эсгий гэрээрээ сольж авсан ба бэлтгэлд тэнцэхгүй 12 хонио бэлтгэлд тохирох таван хониор сольж, мөн эм хонь зургааг хурганаас нь салгаж тус тус бэлтгэлд өгөх зэргээр албан журмын бэлтгэлийн үүргээ чадан ядан хангасан байна. Бас бэлтгэлд тэнцэхгүй зургаан ямаагаа хоёр хязгаалан ямаагаар сольж бэлтгэлд тушаагаад малчин Жамц нь тугалтай үнээ 5, шүдлэн үхэр нэг, нийт зургаан толгой малтай, орох оронгүй хоцорчээ²⁵. Түүний аж ахуй малаа барсан шалтгаан нь ховордсон эр малыг өндөр үнээр худалдан авч, улсын бэлтгэлд тушаасан явдал байна. Бидний үзсэн жишээ зөвхөн мал бэлтгэлийг харуулах бөгөөд малаас гадна түүхий эд, сүү, ноос бэлтгэл нь малчдын амьдралд мөн адил хүнд дарамт болж байв. Энэ тухайд, Хөвсгөл аймгийн Идэр сумын малчид “Сүүг [улсын бэлтгэлд - Н.А.] их авснаас цагаан идээгээр ховордож, мал өсгөхөд хортой болж байна” хэмээн гомдол гаргаж байсныг дурьдсанаар хязгаарлая²⁶.

Улсын бэлтгэлийн хүрээнд малчдаас худалдан авах малын үнэлгээ нь малчдын амьжиргаанд нөлөөлсөн хүчин зүйлүүдийн дотроос тухайн үеийн албан байгууллагуудаас боловсруулсан тоо баримт ба эдийн засгийн бусад судалгаанд хамрагдаагүй үлдсэн бас нэгэн хүчин зүйл юм.

Малчдаас улсад албан журмаар хонь худалдан авах үнийг 1950 оны байдлаар 10 төгрөгөөр тогтоосон байсан²⁷ ба үүнийг Хоршоодын холбооны 1950 оны өргөн хэрэглээний барааны үнийн жагсаалтад үндэслэн харьцуулвал²⁸ нэг нас гүйцсэн хонины оронд малчин айл 5.8 кг 1-р гурил авч байв. Эсвэл энэ 10 төгрөгөөр 2-р гурил 7.6 кг буюу эсхүл 2.5 кг элсэн чихэр авдаг байжээ. Энэ үнийг өнөөгийнхтэй харьцуулвал даруй 10-15 дахин хямд байгаа хэрэг юм. Зөвхөн хонь ч ийм хямд байсангүй, амьд үхэр, адуу, эсвэл хонины ноосыг мөн ихээхэн хямд үнээр албадан худалдан авч байв. Тухайлбал, ажлын нэг адууг улсад тушаагаад олсон мөнгөөр улсын дэлгүүрээс 2 дугаар гурил 100 кг, эсвэл ногоон цай 26 кг буюу даалимба 108 метрийг худалдан авч чадах ажээ.²⁹ Энэ нь өнөөгийн ханшаар нас гүйцсэн нэг адууг нэг төлөгний үнээр улсад худалдаж буй хэрэг болно. 1948-1952 оны хугацаанд малчдаас жил тутам идэш ба бусад зүйлд зарцуулдаг малын тоо 3-аас 3.5 сая болж хагас сая гаруй толгойгоор өссөн нь малчдын дунд малаа зарцуулах явдал ихээр нэмэгдсэнийг харуулж байна³⁰. Ийнхүү малаа улсад албан журмаар худалдахдаа хэт хямд, үнэгүй шахам өгч байсан нь малчдын дунд өргөн хэрэглээний бараагаар гачигдах, хэрэгцээгээ хангахын тулд малаа улам ихээр зарж үрэх байдалд түлхэж, ялангуяа 200 хүртэлх малтай ядуу ба дундаж малчдын малын

²⁵ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 108.

²⁶ МУУТА, Ф-8, Д-2, ХН-483, 24.

²⁷ МУУТА, Ф-1, Д-5, ХН-167, 34.

²⁸ МУУТА, Ф-1, Д-5, ХН-167, 36.

²⁹ МУУТА, Ф-1, Д-4, ХН-178, 39.

³⁰ МУУТА, Ф-8, Д-2, ХН-658, 95.

тоо 44 хувиар багасахын бас нэг шалтгаан болжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дууссанаас хойш нэгдэлжүүлэх хөдөлгөөн ялах хүртэлх үед БНМАУ-ын эдийн засаг эрчимтэй хөгжиж, төмөр зам тавигдаж, аж үйлдвэрийн систем бий болсон, социалист блокын улсуудтай худалдаа хийж, улс орон эрчимтэй хөгжиж эхэлсэн боловч үүний хамт энэ хугацааны эхэн үед малчдын дунд ядуурал нэмэгдэж байсныг бид үзлээ. Ийнхүү малчдын дунд баян, хоосны ялгаа нэмэгдэж байсны шалтгаан нь, нэгдүгээрт, Малчдаас албан журмаар улсад мал, мах, ноос, түүхий эднийг үлгэх журам нь ногдлыг бэлэн байгаа малд биш, харин улсаас хуульчлан баталсан мал өсгөх төлөвлөгөөний тоогоор оногдуулж байснаас ядуу ба дундаж малчдаас улсын бэлтгэлд бололцооноосоо хэтилүүг тушаах ёстой болсон, хоёрдугаарт, Улсын бэлтгэлд нийт эр хонь, эр үхрийн 70-80 хувийг худалдан авч байснаас бэлтгэлд тэнцэх мал ховордож, ядуу ба дундаж малчид бэлтгэлд тэнцэх мал худалдан авахын тулд илүү их мал зарцуулах, чинээлэг малчид улсын бэлтгэлд тэнцэх малаа олон толгой малаар арилжих нөхцөл бүрдүүлсэн, гуравдугаарт, Малын үнэлгээ хэт хямд байснаас улсын бэлтгэлд мал тушаах нь малчдын хувьд цэвэр алдагдал байсан.

Эдгээр шалтгааны улмаас 1948-1952 онд хэрэгжсэн Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний хугацаанд ядуу ба дундаж малчин өрхүүд их хэмжээний алдагдал хүлээж, ядуу малчдын нийт малын тоо 2.1 саяас 1.1 сая болж, дундаж өрхийн малын тоо 10.4 сая мал болж тус тус их хэмжээгээр хорогдсон ба харин чинээлэг давхаргынхны малын тоо 7.2 саяас 9.8 сая болон өсч, БНМАУ-ын хүн амын 90 гаруй хувийг эзлэх малчдын дунд баян, ядуугийн ялгаа эрс нэмэгджээ.

4. Улсын бэлтгэл ба эрх баригчдын бодлого

Малын бодит тоонд биш, улсын төлөвлөгөөгөөр заасан тоонд үндэслэн, улсын бэлтгэлд нийт эр үхэр ба хонины дийлэнх олонхыг малчдаас улсад хямд үнээр худалдан авч байсан явдал бол эн тэргүүн БНМАУ-ын эрх баригчдын бодлого, үйл ажиллагаатай холбогдох юм. Энэ талаарх эрх баригчдын бодлогыг Анхдугаар таван жилийн төлөвлөгөө, улсын бэлтгэлийн төлөвлөгөө, үнийн бодлого хэмээн гурван хэсэгт хуваан үзэж болно.

1947 оны 12-р сард эрх баригч МАХН-ын 11-р их хурлаар 1948-1952 онд Улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх Анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталж, түүнийг улс даяар даган мөрдүүлэхээр шийдвэрлэжээ. Уг төлөвлөгөө ёсоор 1952 он гэхэд улсын нийт мал сүрэг 31 саяд хүрч өсөх ёстой байв. Таван жилийн төлөвлөгөөг аймаг, сум, баг, өрх бүрт хуваарилан хүргэж, хүн бүр заавал биелүүлэх хууль ёсны үүрэг болгон тунхаглав. “Улсын төлөвлөгөө бол хөдөлшгүй хууль юм” хэмээн эрх баригчдын Үнэн сонинд бичжээ³¹. Ийнхүү мал сүргийн

³¹ Хонины ахар, хурганы ноос бэлтгэх төлөвлөгөөг амжилттай биелүүлье. Үнэн. 1951. №188 (4874).

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний
жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл

тоо толгойг хөдөлшгүй төлөвлөгөөнд захируулах болсноор малаа өсгөж чадаагүй малчдыг төлөвлөгөөнд зааснаар илүү олон малтай хэмээн тооцож улсад тэднээс их хэмжээний малыг худалдуулах боломж бий болжээ

Мал сүргийн 99 хувийг өмчилж байсан ардын аж ахуйтны 1952 оны мал өсгөх төлөвлөгөө 26.8 сая байсан бол гүйцэтгэл нь 22.2 сая болж, 82.6 хувийн гүйцэтгэлтэй байжээ³². Энэ их тоо нь гагцхүү 1952 онд гарсан хэрэг биш бөгөөд 1949 онд 233, 1950 онд 1167.1, 1951 онд 1355.9 мянган толгой, 1952 онд 1922.6 мянган толгой малаар тус тус төлөвлөгөө тасалдуулж ирснээс хуримтлагдаж, 1952 онд тоологдсон мал нь уул төлөвлөгөөнөөс 4 сая 667.6 мянган тоогоор дутах болсон бөгөөд төлөвлөгөөг тасалдуулах явдал жил бүр нэмэгдэх болжээ³³. Улсын хэмжээнд бүх малчин өрхийн 62.3 хувь нь 1951 оны мал өсгөх төлөвлөгөөг тасалдуулж, түүний дотор бүх малчин өрхийн 41.7 хувь нь урьд онд байсан малаа хорогдуулжээ. Энэ хувь хэмжээ жилээс жилд өссөн нэмэгдсээр байв³⁴. Төлөвлөгөө нь ердөө биелэшгүй мөрөөдөл болон хувирав.

Гэтэл албан татвар, мал бэлтгэлийг малчдаас гаргуулахдаа бодит байдал дээр огт байхгүй цаасан дээрх 4 сая гаруй хий малыг байгаагаар нэмэгдүүлэн тооцож тэр нийт дүнгийн хэмжээгээр малын мах, сүү, ноос, бусад ашиг шимийг нь байгаа малаас нь албадан гаргуулж авч байв. Засгийн газраас орон нутгийн захиргаанд хандан “малыг бэлтгэх ба тууварлах төлөвлөгөөг үг дуугүйгээр ханган биелүүлэхийг та нарт үүрэг болгосугай” хэмээн тушааж байв³⁵. 1952 онд Завхан аймгийн Бага хурлын Тэргүүлэгчдийн даргын Нэгдүгээр орлогч Сахьяагаас “...зудаар үхсэн малыг чөлөөлөхгүй, ийм учир бэлхэн байгаа бэлтгэлд тэнцэх малаа бүгдийг туух хэрэгтэй, малгүй болсон аж ахуйтныг малаа олж тушаа гэж шаардах хэрэгтэй” гэж мэдэгдэж байсан нь тэр үеийн түгээмэл дүр зураг байв³⁶.

Энэ байдлыг 1952 оны улсын бэлтгэлийн төлөвлөгөөгөөр жишээлэн авч үзье. 1952 оны Монгол-Зөвлөлтийн харилцан бараа нийлүүлэх гэрээ ёсоор Монголын тал Зөвлөлтөд 130 мянган тонн мал тушаахаар үүрэг хүлээжээ. 1951 оны 8 дугаар сарын мал тоологоор улсын хэмжээнд 22.7 сая мал тоологджээ. Харин мал өсгөх хуульчилсан төлөвлөгөөний дагуу 1952 онд 27 сая мал байх ёстой ажээ³⁷. 1952 оны улсын бэлтгэлийн төлөвлөгөөг хийхдээ бэлэн байгаа 22.7 сая малд биш, харин төлөвлөгөөгөөр байх ёстой 27 сая малд оногдуулан нийт 143.3 мянган тонн мал бэлтгэхээр төлөвлөсөн байна.³⁸

Ийнхүү Анхдугаар таван жилийн төлөвлөгөө ба улсын бэлтгэлийн төлөв-

³² МУУТА. Ф-8. Д-2, ХН-543, 4.

³³ МУУТА. Ф-8. Д-2, ХН-543, 3-5

³⁴ МУУТА. Ф-8. Д-2, ХН-658, 1.

³⁵ МУУТА. Ф-1. Д-4. ХН-7, 212.

³⁶ МУУТА, Ф-8. Д-2, ХН-483, 31.

³⁷ МУУТА. Ф-8, Д-2, ХН-658, 1.

³⁸ МУУТА. Ф-8, Д-2, ХН-553, 110.

лөгөө нь малын бодит тоонд тохирохгүй байснаас нийт малчдын 60-70 хувьд хэрээс хэтэрсэн улсын бэлтгэлийн үүрэг оногдох болж, улмаар малчид ядуурах нэг шалтгаан болж байжээ.

Малчдын ядууралд холбогдох эрх баригчдын явуулсан удаах бодлого бол үнийн бодлого юм. Бид малчдаас улсын бэлтгэлд мал худалдан авах үнийг дээр дурьдсан билээ. Тэгвэл малчдын аж амьдралд нөлөөлөх мал ба бараа таваарын үнэ нь малчдаас мал худалдан авах үнэ, түүнийг Зөвлөлтөд тушаах үнэ, Зөвлөлтөөс бараа, материал худалдан авах үнэ, тэдгээрийг малчдад борлуулах үнэ гэсэн тойрогт оршиж байв. Энэ тойргийн үе шат бүрт Засгийн газар их хэмжээний цэвэр ашиг олж, түүгээр улсын төсвийн орлогын ихээхэн хэсгийг бүрдүүлж байв. Мал, түүхий эдээс гаралтай баялгийн бүрдүүлэлт ба хуваарилалтаас малчид хэрхэн хохирч байсныг харахын тулд 1. Малчдаас мал худалдан авснаас эхлээд Зөвлөлтөд мал, түүхий эд тушаах хүртэлх бүрдүүлэлтийн шат, 2. Зөвлөлтөөс бараа, материал худалдан авахаас эцсийн хэрэглэгчид очих хүртэлх хуваарилалтын шат хэмээн хувааж үзэж, малчдаас мал, түүхий эд худалдан авахад зарцуулсан мөнгөн дүн ба түүнийг Зөвлөлтөд экспортолсон мөнгөн дүнг харьцуулъя.

Анхдугаар таван жилд бэлтгэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн тоо ба үнийн талаар багагүй өсөлт үзүүлжээ. 1948 онд улсын хэмжээнд нийт 87.3 сая төгрөгийн мал, түүхий эдийг бэлтгэсэн бол 1952 онд 121.2 сая төгрөг болж нэмэгджээ³⁹. Үүний дотор мал ба ноос хамгийн их дүнг эзлэх юм. Энэ хугацаанд нийт 627.4 сая төгрөгийг малчдаас албан журмаар мал, түүхий эд худалдан авахад зарцуулжээ. Тэгвэл эдгээр бүтээгдэхүүний 90 гаруй хувийг Зөвлөлтөд экспортлоодуг хугацаанд нийт 1012 сая төгрөгийн бохир орлого олсныг доорх хүснэгтээс үзэж болно.

Хүснэгт 4. БНМАУ-ын экспорт (сая төг)

1947 он	1948 он	1949 он	1950 он	1951 он	1952 он
149.1	134.8	144.1	156.8	224.9	202.4

Эх сурвалж: Мещеряков М.В., Зөвлөлт Холбоот Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдийн засгийн хамтын ажиллагааны тойм. Улаанбаатар. 1959. т.102,106

Зөвлөлттэй байгуулсан Харилцан бараа нийлүүлэх гэрээнд заасан үнээр мал, түүхий эдийг нийлүүлэх ажлыг гүйцэтгэхийн тулд малчдаас хямд үнээр авахаас өөр аргагүй байжээ. Тухайн үед улсын нийт ачаа эргэлтийн 60 гаруй хувийг ердийн хөсгөөр гүйцэтгэж, тээврийн зардал нь худалдааны зардлын 40 гаруй хувийг эзэлж байсан тул улсын бэлтгэлийн хүрээнд цугларсан мал, түүхий эдийг Зөвлөлтийн хилд үндсэн дөрвөн чиглэлээр тээвэрлэн хүргэхэд гарах зардлаас хямд үнээр мал, түүхий эдийг малчдаас худалдан авсны үндсэн дээр улсын бэлтгэлийн систем алдагдалгүй ажиллах ёстой байжээ. Энэ үүднээс Зөвлөлтөд мал, түүхий эдийг тушаасан үнэ нь бүхэлдээ малчдаас худалдан авсан үнэ, тээврийн зардал


³⁹ Лувсандорж. П., БНМАУ дахь худалдааны хөгжил. УБ, 1968, 79-80.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл

гэсэн хоёр зүйлийг л нөхөж чаддаг, харин энэ худалдаанаас ямар нэгэн нэмэлт ашиг алга байжээ гэж үзэж болно. Мэдээж арай хожим, Улаанбаатар-Наушкийн төмөр зам ажиллагаанд бүрэн орсон 1950-иад оны эхэн үеэс эхлэн тээврийн зардал төвийн бүс нутгаар хямдарч, улсын бэлтгэлийн систем Зөвлөлтөд гаргах экспортын төвийн чиглэлээс ашиг олох боломж бүрдэж иржээ. Ийнхүү 1948-1952 оны хугацаанд Зөвлөлтөд худалдах мал, түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх аргаар бус, харин малчдаас худалдан авах үнийг үнэгүй шахам байлгах аргаар улсын бэлтгэлийн системийн хэвийн ажиллагааг хангаж байсан тул Зөвлөлтийн талын өмнөөс БНМАУ-ын малчид хэмжээний эдийн засгийн алдагдал хүлээж байсан ба улсын бэлтгэлийн бүрдүүлэлтийн шатан дахь үнийн энэ бодлого нь малчдын ядуурлын нэгэн үндсэн нөхцөл болжээ.

Улсын бэлтгэлийн хүрээнд бий болсон нөөц баялгийг Зөвлөлтөд тушаагаад оронд нь худалдан авсан зүйлсийг бараа, техник хэмээн хоёр ангилан үзнэ. Бараа гэдэгт гурил, хүнс, өргөн хэрэглээний бараа, эд таваар, хувцас, тавилга орох бол техник гэдэгт автомашин, сэлбэг, үйлдвэрийн багаж, тоног төхөөрөмж, шатах тослох материал зэрэг техник, технологийн зүйлс орно. Малчдын бий болгосон мал, түүхий эдийг улсын бэлтгэлийн хүрээнд цуглуулж, Зөвлөлтөд тушааснаар БНМАУ-ыг бараа, техникээр хангаж байв. Ю.Цэдэнбалаас улсын бэлтгэл нь БНМАУ-ыг бараа таваараар хангах гол арга болохыг цохож «Ард түмэнд хэрэглэгдэх эд товар хийгээд манай өсөж байгаа үйлдвэрт хэрэглэгдэх эд материал, зэвсэг багажийг худалдан авч оронд нь экспортод гаргадаг зүйл бол мөн мал аж ахуйгаас голцуу гардаг болно» хэмээн тэмдэглэж байв⁴⁰.

График 7



БНМАУ Зөвлөлтөөс жилд дунджаар 170-300 сая төгрөгийн бараа, техникийг худалдан авснаас тэн хагас буюу 150-200 орчим сая төгрөгийн үнэ нь хүнс, өргөн хэрэглээний бараа байв. БНМАУ-ын улсын ба хоршооны худалдааны хөгжлийн тоо баримтууд хэмээх эмхтгэлд үзүүлснээр улсын ба хоршооллоор худалдаалсан жижиглэнгийн бараа гүйлгээний дүн дараах байдалтай байна.

⁴⁰ Монгол Ардын Хувьсгалт Намын 11 дүгээр Их Хурал дээр 1948-1952 онуудад Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний тухай нөхөр Цэдэнбалаас тавьсан илтгэл ба түүнд гаргасан тогтоол, УБ., 1948, 9.

Хүснэгт 5. БНМАУ-ын улсын ба хоршооллын худалдааны жижиглэн худалдаалсан бараа гүйлгээ, 1947-1952 он, сая төгрөгөөр

	1947 он	1948 он	1949 он	1950 он	1951 он	1952 он
Жижиглэн худалдааны дүн	322.1	322.8	297.2	307.1	352.3	320.8

Эх сурвалж: БНМАУ-ын улсын ба хоршооны худалдааны хөгжлийн тоо баримтууд, ШУА-ийн Түцхийн хүрээлэнгийн Баримтын төв, Ф-5, Д-1, ХН-109, 13.

Улсын дотоодын жижиглэнгийн худалдаагаар жилд 300 орчим сая төгрөгийн барааг худалдаалж байв. Жижиглэнгийн худалдааны барааны ихэнхийг импортын бүтээгдэхүүн, бага хэсгийг дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байсан ба импортын бүтээгдэхүүнийг жижиглэнгээр худалдахдаа анх авсан үнийг бага бус нэмэгдүүлж байсан тул ийнхүү жижиглэнгийн үнийн дүн импортоор авсан барааны нийт дүнгээс хувь илүү өсөлттэй гарч байв. Тухайлбал, улсын ба хоршооны худалдааны байгууллагуудаас Засгийн газарт 1951 онд ирүүлсэн үнийн жагсаалтаас үзвэл, 1-р гурилыг Зөвлөлтөөс 65 мөнгөөр аваад, ард иргэдэд 1.70 төгрөгөөр, цагаан будааг 70 мөнгөөр аваад 2.70 төгрөгөөр, асперин 1 кг-ыг 4.60 төгрөгөөр аваад 30 төгрөгөөр зарж байжээ. Үнэ нэмэгдүүлэх байдал импортын ихэнх бараанд ажиглагдах бөгөөд дүнсэн тамхи зэрэг цөөн барааг Зөвлөлтөөс авсан үнээс бага зэрэг хямдруулан зарж байв⁴¹.

Энэ байдал нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэх шаардлагатай холбоотой бөгөөд мал, түүхий эдийн улсын бэлтгэл, улс, хоршооллын жижиглэнгийн худалдаанаас олох орлогыг гүйлгээний татвар, ашгийн шимтгэл, төсвийн нэмэгдэл зэрэг хэлбэрээр улсын төсөвт татан төвлөрүүлж, боловсрол, эрүүл мэндэд шаардлагатай 70 сая, батлан хамгаалахын 100 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж байв.

Улсын бэлтгэлийн систем ба түүний нөгөө тал болсон улсын худалдаа нь Анхдугаар таван жилийн хугацаанд малчдаас мал, түүхий эд худалдан авах ба малчдад бараа, бүтээгдэхүүн худалдаалахдаа ийнхүү малыг хямд үнээр худалдан авч, бараа, бүтээгдэхүүнүүдийг багагүй үнэ нэмэгдүүлэн зарж, малчдыг хоёр давхар хохироож байсан нь малчдын орлогыг хааж, гурил, таваараар хомсдох, хэрэгцээгээ хангахын тулд мал сүргээ зарж борлуулах, улмаар 1948-1952 онд үй олноороо ядуурч доройтоход нөлөөлжээ.

Улс, орноо тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн замд оруулахаар зорьж байсан эрх баригчид яагаад ихэнх иргэдийнхээ амьдралд хүнд туссан бодлого, үйл ажиллагаа явуулах болов? Үүний шалтгааныг БНМАУ-ын гадаад орчин ба Зөвлөлтөөс БНМАУ-ын талаар явуулсан эдийн засгийн бодлоготой холбогдуулан авч үзэх нь зүйтэй.

⁴¹ МУУТА, Ф-1, Д-5, ХН-167, 36-38.

5. БНМАУ-ЗХУ-ын Харилцан бараа нийлүүлэх гэрээ ба БНМАУ-ын мал экспорт

БНМАУ-ЗХУ-ын худалдааны гол хөтөлбөр нь Харилцан бараа нийлүүлэх гэрээ ба түүний хүрээнд байгуулагдсан жил тутмын худалдааны гэрээ юм. Энэ үеийн БНМАУ-ЗХУ-ын харилцан бараа нийлүүлэх ба худалдааны гэрээ хэлэлцээрүүдэд Зөвлөлтийн эдийн засгийн дотоодын байдал, дайны дараах хүндрэл бэрхшээл зохих тусгалаа олж байв. Дайны улмаас Зөвлөлтийн хөдөө аж ахуй сүйрч, мах үйлдвэрлэл хоёр дахин багасч, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хомсдолд ороод байв. Зөвлөлтөд 1940 онд 1.5 сая тонн мах үйлдвэрлэж байсан бол 1945 онд 663 мянга, 1946 онд 793 мянга, 1947 онд 815 мянга, 1948 онд 1 сая, 1949 онд 1.1 сая тонн мах үйлдвэрлэж⁴², 1945 онд нэг хүн тутамд жилд 6.6 кг, 1946 онд 7.9 кг, 1947 онд 8.1 кг, 1948 онд 10 кг, 1949 онд 11 кг мах оногдож байв. Үүний хамт 1946 онд Зөвлөлтийн Украин, Молдав, Хар тэнгисийн төвийн бүс, Ижил мөрний дундад хэсгээр сүүлийн тавин жил болоогүй хуурай ган болж, газар тариаланчид ургац алдан дайны өмнөх үеэс 2.6 дахин бага ургац хурааж авч⁴³, оросын ард түмэнд хүнд өлсгөлөн нүүрлэжээ. Энэ нь Орост сүүлийн тавин жил болоогүй хатуу ган байжээ. Иймээс Зөвлөлтийн хувьд мах импортлох явдал дайны дараах үеийн нэн тулгамдсан асуудлын нэг болж байв.

ЗХУ дайны дараах үед хоол, хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор хүнсний малын импортоо нэмэгдүүлэх талаар Монголын талд удаа дараа санал тавьжээ. 1947 оны 1-р сард ЗХУ-ын Гадаад худалдааны яамны орлогч сайд Миконовоос Москва хотод сууж буй БНМАУ-ын худалдааны төлөөлөгч Лувсанг урьж уулзалт хийж, “Манай улсын идэш уушны байдал хүнд байгаа учраас танайхаас гаргах бүх малын махыг 120 мянган тонн ба өөх тосны зүйлийг 5000 тонн хүртэл нэмэгдүүлэн гаргаж өгөхийг” хүсчээ⁴⁴. Тухайн үед Зөвлөлтөд жилд 1 сая орчим тонн мах үйлдвэрлэж байсан бөгөөд Монголоос авах энэ 120 мянган тонн мах нь Зөвлөлтийн тухайн үеийн нийт махны үйлдвэрлэлийн 12 орчим хувьтай тэнцэж байв.

Монголчуудын хувьд энэ хэмжээний мах бол ойролцоогоор 3 сая орчим толгой мал болох ба улсын хэмжээнд нэг жилд бойжуулдаг төлийн тэн хагастай тэнцэх агаад ийм хэмжээний малыг экспортод гаргаснаар мал сүргийн өсөлтийг шууд зогсооход хүргэх байлаа. Худалдааны төлөөлөгч Лувсан Ерөнхий сайд Чойбалсантай удаа дараа харилцаж, зөвлөлдсөний эцэст «их ахынхаа» хүсэлтийг арга буюу хүлээн авч, 1947 онд нийлүүлэх махны хэмжээгээ 120 мянган тонн болгож буйг 1947 оны 2 дугаар сарын 24-ний өдөр мэдэгджээ⁴⁵. Мөн 1948

⁴² *Soviet Industrial Output*. 1940-1985. Marxist internet archive: <http://marxists.org/>

⁴³ Поляк. Г.Б., *Послевоенное восстановление народного хозяйства*. М., 1986.118.

⁴⁴ МУУТА. Ф-1, Д-4. ХН-127. 11-12.

⁴⁵ МУУТА. Ф-1, Д-4. ХН-127. 7-10.

онд Монголын талаас Хоршоодын төв холбоо ба Зөвлөлтийн талаас Мал импорт нэгдлийн байгуулсан 1948 оны малын гэрээгээр Монголын тал Зөвлөлтөд 1948 онд бүх том ба жижиг малыг амьдын жингээр нийт 79300 тонныг гэрээнд заасан үнээр худалдах үүрэг хүлээжээ.⁴⁶

Ийнхүү Зөвлөлтийн тал өлсгөлөнгөөр шалтгаан зааж Монголоос авах мал, түүхий эдээ 1947 онд эрс нэмэгдүүлээд, хүнсний хангамж сайжирсан дараа дараачийн жилүүдэд буцааж цөөрүүлэлгүй улам өсгөсөөр 1981 онд улсын бэлтгэлийн хүрээнд цуглуулж Зөвлөлтөд экспортлох малын амьдын жин 200 мянган тоннд хүрчээ⁴⁷.

Зөвлөлтийн хувьд дайны дараа Монголоос мал үргэлжлүүлэн худалдаж авах өөр нэг шалтгаан байсан нь дайны үед Сибирьт нүүлгэн шилжүүлэх буюу шинээр барьж байгуулсан махны үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах сонирхол байв. Чита, Улаан-Үд, Томск зэрэг хотууд дахь томоохон махны үйлдвэрүүд нь Монголын хонь, үхрийн махаар хيام, лаазалсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улс даяар ба мөн БНМАУ-д худалдаалдаг байлаа. Ийнхүү Монголын малыг Зөвлөлт рүү хямд үнээр, их хэмжээгээр гаргах явдал огт сааралгүй эрчимтэй үргэлжилж, энэ үйл явц малчдыг нэгдэлжүүлж мал сүрэг «харж хандах эзэнгүй» болсны дараа улам далайцтай, их хэмжээтэй явагдах болжээ.

Харилцан бараа нийлүүлэх гэрээгээр Монголын талаас авах малын тоо хэмжээг ийнхүү Зөвлөлтийн талын саналаар шийдэж байсан бол түүний үнэ ханшийг мөн адил Зөвлөлтөд ашигтай байдлаар тогтоож байлаа. Улсын төлөвлөгөөний комиссоос 1946 онд хийсэн судалгааг үзвэл 1939-1946 оны хооронд Зөвлөлтөөс Монголд импортолдог бараануудын үнэ дунджаар 40-347 хувиар нэмэгдсэн байхад Монголоос Зөвлөлтөд экспортолдог голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ бараг өссөнгүй. Тухайлбал Зөвлөлтийн 2-р гурил 1 кг нь 1939 онд 11 мөнгө байсан бол 1945 онд 43 мөнгө болж 289 хувь, мөн ёотон 356 хувь, шүдэнз 118 хувь гэх мэтээр үнэ нэмэгдсэн байна⁴⁸. Монголын ихэнх мал, түүхий эдийн экспортын үнэ бараг өсөөгүй ба тухайлбал үхрийн ширийг Зөвлөлтөд 1939 онд нэг ширхгийг 14 төгрөгөөр зардаг байсан бол 1945 онд 15.2 төгрөг болж зургаан жилийн хугацаанд үнэ нь үл ялиг нэмэгджээ⁴⁹.

Энэ байдал хожим ч мөн адил давтагдаж байв. Судлаач Т.Намжимын тэмдэглэснээр, 1975-1990 оны хооронд Зөвлөлтөөс худалдан авдаг бүтээгдэхүүний үнэ дунджаар 500-600 хувь нэмэгдсэн байхад Монголоос Зөвлөлт рүү нийлүүлдэг бүтээгдэхүүний үнэ дунджаар 36 хувь өссөн ажээ⁵⁰.

⁴⁶ МУУТА, Ф-17, Д-1, ХН-416. 1-2.

⁴⁷ БНМАУ-ын улс ардын аж ахуй, УБ, 1982, 153.

⁴⁸ МУУТА, Ф-8, Д-1, ХН-508. 14-15.

⁴⁹ МУУТА, Ф-17, Д-1, ХН-343. 1.

⁵⁰ Намжим, Т., *Монгол улсын эдийн засаг: Эрт, эдүгээ, чинагш*, 2-р боть, УБ, 2004, 757.

Энэхүү үнийн тэгш биш өсөлтийн улмаас 1940 онд хил дээр нэг хонь Зөвлөлтийн 86 кг орчим 2-р гурилтай тэнцдэг байснаа 1950 онд ойролцоогоор 46 кг 2-р гурилтай тэнцэх болж, Монголын хонины хилийн үнэлэмж бараг хоёр дахин буурч, тэр хэмжээгээр Монголын эдийн засагт алдагдал үүсч, тэр алдагдлыг хүн амын ихэнхийг эзлэх малчин ардууд улсын бэлтгэлийн хатуу журмын хүрээнд үүрэхэд хүрчээ.

Зөвлөлтийн талаас БНМАУ-ын эрх баригчид ба улсын бэлтгэлийн байгууллагуудыг БНМАУЗХУ-ын хооронд байгуулсан Харилцан бараа нийлүүлэх гэрээгээр хүлээсэн Зөвлөлтөд мал, түүхий эд тушаах үүргээ хатуу сахин биелүүлэхийг шаардаж байв. Улаанбаатарт суугаа Зөвлөлтийн худалдааны төлөөлөгчөөс “Та, танай Засгийн газар өөртөө хүлээсэн үүргийг биелүүлэх хариуцлагыг бүрэн мэдэж байгаа байх. БНМАУ-ын Засгийн газраас өөртөө хүлээсэн энэхүү үүргийг биелүүлэх талаар арга хэмжээ авч байна гэж би ч зохих газартаа мэдэгдэж байлаа. Одоо тэргүүн хагас жил дуусах шахамдаж байна.

Гэтэл танайхаас түүхий эд зэргийг экспортод тушаах явдал зарим талаараа удааширч байна”⁵¹ гэх буюу мөн “...Ер нь дээр дурьдсан зүйлүүдийг Монгол улсын талаас биелүүлэхгүйд хүрвэл Контракта давсан олон үүрэг нь үл биелэгдэхэд хүрэх гэж байна” хэмээн анхааруулж байжээ⁵². Энэ нь Зөвлөлтийн талаас БНМАУ-д нийлүүлдэг гурил, даавуу, шатахуун, сэлбэг зэрэг чухал шаардлагатай бараа, бүтээгдэхүүнүүдийн хангалтыг шууд зогсооно гэсэн үг байв. Чухам энэхүү хатуу шаардлагын доор БНМАУ-ын эрх баригчид орон нутгийн захиргаа, малчин ардиргэд бүрт хатуу заасан үүрэг оногдуулж, биелүүлээгүй хүмүүсийг шоронд хорих хүртэл арга хэмжээ авч байжээ.

Ийнхүү БНМАУ-ЗХУ-ын харилцан бараа нийлүүлэх гэрээ ба худалдааны хэлэлцээрүүдийн дагуу БНМАУ-аас олон мянган тонн малыг Зөвлөлтөд нийлүүлэхдээ 5-аас 10 жилээр хоцрогдсон тарифыг мөрдөж байснаас БНМАУ-ын хувьд анхнаасаа эцэс хүртэл хохиролтой худалдаа явагдаж байжээ.

Хоёр улсын улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол зэрэг бүх талын харилцаанд тогтсон Зөвлөлтийн давуу эрх нь Анхдугаар таван жилийн хугацаанд болон түүхийн бусад үед Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийг доогуур төвшинд барьж байх, өөрсдийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үнийг жил тутам нэмэгдүүлэх боломжийг олгож байв.

⁵¹ МУУТА. Ф-1. Д-6. ХН-704. Т.101.

⁵² МУУТА. Ф-1. Д-6. ХН-704. Т.97.

Дүгнэлт

1952 онд Сэлэнгэ аймгийн 40 толгой малтай эгэл ядуу малчин ард Жамц улсадалбан журмаар мал, түүхий эд тушаах үүргээ ханган биелүүлснээс шалтгаалж ядуурчээ. Мал өсгөх хуульчилсан төлөвлөгөө ба түүндүндэслэсэн улсын бэлтгэлийн ноогдлын дагуу Жамц ба бусад олон малчид байгаагаасаа илүүг улсад тушаах ёстой болж байв. Улсын бэлтгэлд нас гүйцсэн эр мал авах шаардлага тавигдсанаас нэг жилийн дотор улсын хэмжээний эр хонь ба эр үхрийн 70-80 хувийг тууварлан экспортлох болж, улсын бэлтгэлд тэнцэх эр малтай болохын тулд малчид илүү олон толгой мал зарцуулах болжээ. Анхдугаар таван жилийн хугацаанд ядуу малчдын эзэмших нийт малын тоо 40 хувиар хорогджээ. Тухайн үеийн худалдааны байгууллагын үнийн жагсаалтаас үзэхэд улсын бэлтгэлд тушаасан нэг хонины оронд малчид 10 хүрэхгүй кг гурил авч байжээ. Чухам малыг үнэгүй шахам авч байсан учраас үүнийг албадлагаар хэрэгжүүлэхэд хүрч, «албан журмын мал, түүхий эд бэлтгэл» гэдэг нэр томъёо үүсчээ.

Малчдаас ийнхүү хямд үнээр, их хэмжээгээр, албан журмаар мал худалдан авч, малчдыг ядууруулах болсон явдал нь Харилцан бараа нийлүүлэх гэрээгээр Зөвлөлтөд мал тушаахаар хүлээсэн БНМАУ-ын үүрэгтэй холбоотой байв. Зөвлөлтөд мал, түүхий эд экспортолноор улсын төсвийн орлогын ихэнх хэсгийг бүрдүүлж, өргөн хэрэгцээний бараа, материал, үйлдвэрийн ба тээврийн тоног төхөөрөмжийг худалдан авах хөрөнгийг бий болгож байв. Большевикуудын хувьд Сибирийн махны үйлдвэрүүдэд зориулж Монголоос их хэмжээний малыг хямд үнээр худалдан авах явдал БНМАУ-тай байгуулдаг Харилцан бараа нийлүүлэх гэрээний нэг зорилго байв. Энэ худалдаа дэлхийн хоёрдугаар дайны үед эрс ихэссэн ч дайны үед Зөвлөлтийн барааны үнэ хэд дахин нэмэгдсэнээс шалтгаалж дайн дууссаны дараа Монголын талд их хэмжээний алдагдал үүссэн байна. Энэ алдагдал нь эцэстээ малчдын нуруун дээр бууснаас тийнхүү малчдын дунд ядуу ба дундаж малчид ядуурах явдал ихэсчээ.

Эрх баригчдын цаашдын бодлого Зөвлөлттэй хийх худалдааны алдагдлыг бууруулахад биш, харин энэ нөхцөл байдалд дасан зохицоход эн тэргүүн чиглэгдэж, малчдын хувийн малд улсын бэлтгэлийн үүрэг оногдуулах замаар хувийн малыг хавчих болсны улмаас малчид улсын бэлтгэлийн хүнд үүрэг, ялаас зугатаах зорилгоор 1958-1960 онд “сайн дураар” нэгдэлд нэгдэх болсон нь БНМАУ-д нэгдэлжүүлэх хөдөлгөөн ялах эдийн засгийн хүчин зүйлүүдийн нэг болсон байна.

Abstract: Jamts, a herder from Selenge province was impoverished due to the obligation to supply his own livestock and goods to the government like with many other herders. It was mandatory according to the Five Year plan of socialist husbandry development. Notably, Jamts had to supply 1.3 tons of meat, for that he had to increase his cattle number from 40 to 226. The government demanded to

supply only ram and ox. 70-80 percent of total ox and rams possessed by the herders were taken for almost no price. The price list record shows that one ram price was less than 10 kilogram of flour. This campaign of purchasing livestock for very low cost was related with the task of MPR to supply livestock to Soviet Union, mainly to meat factories in Siberia under the mutual agreement of trading animal byproducts. Paradoxically, since 1940, cost of livestock supplied to Soviet Union was increased by 30 percent, while cost of goods supplied to MPR from Soviet Union was increased by 100-200 percent. Hence, trade deficit was emerged to Mongolian part under this unprofitable agreement. Ultimately, the system conducted in MPR and USSR was a clear illustration, which reflects the uneven situation for Mongolians and Russians under soviet totalitarian regime aimed to so called "bright communism." Herders were the victims of this socialist "trade." During the first Five Year plan of economic development, total cattle number of all humble herders was decreased about 40 percent, the phenomenon of which is tackled in this article.